



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 01/404

Арвайхээр сум

Тарваган тахал өвчний хяналт, сэргийлэлтийн
арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн "Тарвагыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг түр хугацаагаар хориглох тухай" А/193 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин, үзлэг шалгалтыг эрчимжүүлж, хууль бус ан агнуурыг таслан зогсоох ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Баясгалан), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Уянга, Хайрхандулаан, Нарийнтээл, Тарагт сумдын тарваган тахлын идэвхтэй бүсэд анхааруулах тэмдэг, пайз байршуулахыг тухайн сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Тарвага, тарваганы гаралтай түүхий эдийг худалдаалах зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, орон нутгийн хяналтын постууд болон хөдөө орон нутагт эргүүл шалгалт хийх хуваарь гарган хэрэгжүүлж, илэрсэн зөрчилд хариуцлага тооцон, хураан авсан тарвага, түүний түүхий эдийг Зоонозын өвчин судлалын төвд хүлээлгэн өгч шинжилгээнд хамруулан хамтарч ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Г.Чимэддагва)-т даалгасугай.

4. Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоон дахь хяналтыг сайжруулж, тарвага, тарваганы гаралтай түүхий эдийг нууцаар тээвэрлэх зөрчлийг илрүүлэн, аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Зоонозын өвчин судлалын төвтэй хамтран ажиллахыг Авто тээврийн төв (М.Мөнхбаатар)-д даалгасугай.

5. Тарваган тахал өвчнөөс сэргийлэх зөвлөмж, мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг бүх төрлийн хэлбэрээр зохион байгуулж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0978

D:My Doc. Zahiramj. Zasag darga